



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
Хөтөлбөрийн нэр: УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Индекс: D023203

Шинжээчийн баг:

Ахлагч: С.Байгалсайхан

Гишүүд: П.Нармандах
Д.Өрнөхдэлгэр

2022.05.13

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУИС-ийн ШУС-ийн ХУС School of Sciences, National University of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Утга зохиол судлал Literary studies	
Индекс	D023203	
Шинжээчид	Ахлагч: 1. С.Байгалсайхан. Улаанбаатарын их сургуулийн захирал, доктор Sc.D, профессор Гишүүд: 2. П.Нармандах. Монгол улсын боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Утга зохиолын тэнхимийн багш, доктор, дэд профессор док.дэд профессор 3. Д.Өрнөхдэлгэр. Ховд их сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор	
Зохицуулагч	Б.Оюунчимэг Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.04.22	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.
	2022.04.22	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022.04.29	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны
	2022.04.4-5	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022.05.13	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго: Утга зохиол судлал хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлага болох эрэлт хэрэгцээ чадамжид суурилсан загвартай, суралцагчдын эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын хүсэлт шаардлагад нийцэн өндөр чадвар бүхий боловсон хүчин бэлтгэх

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)

Сүүлийн таван жилийн судалгаагаар уг хөтөлбөрөөр төгсөгчдийн 85 хувь нь ажлын байртай болж, манлайлал ур чадвараар бусдыг хошуучилж байгаа. Энэ чанарыг алдалгүй улам бататгаж, монгол улсад утга зохиолын чадамгай мэргэжилтэн бэлтгэх

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)

Судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, түвшинг дэлхийн жишигт нийцүүлнэ.

Сургах ба суралцах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэнэ.

Нийгэмд мэдлэгээр манлайлж, нийгмийн хөгжлийн түүчээ байна.

Байгууллагын бие даасан байдлыг хангаж, менежментийн олон улсын шилдэг арга барилыг нэвтрүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

- Утга зохиолын судалгааны онол, арга зүйн мэдлэг, ур чадвар хандлагаар судлал шүүмжлэлийн бичвэр бүтээх
- Утга зохиолын түүх, онол, арга зүйн мэдлэг, чадвар, хандлагаа утга зохиол судлалын шууд ба шууд бус практикт хэрэглэх, олон нийттэй харилцах
- Утга зохиолын монгол хэлний мэдрэмж авьяас хийгээд утга зохиолын түүх, онол, арга зүйн мэдлэг, ур чадвар, хандлагадаа тулгуурлан, уран сайхны бичвэр бүтээх, зохиол туурвих
- Утга зохиолын түүх, онол, арга зүйн мэдлэг, ур чадвар, хандлагадаа тулгуурлан утга зохиолоор багшлах, нийгэмд нөлөөлөх зэргээр тодорхойлон мэдлэг, чадвар, хандлага, төгсөгчийн загвар цогц чадамжийн уялдааг дэлгэрэнгүй харуулсан болно.
- МУИС-ийн Утга зохиол судлал хөтөлбөрийн зорилтууд болон хөтөлбөрийн төгсөгчийн загварт тусгагдсан утга зохиолын ажилтны мэргэжлийн цогц чадамжийн мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд сургалтын төлөвлөгөөнд орсон бүх хичээл дангаараа болон бусад хичээлүүдтэй уялдаа холбоотойгоор хувь нэмэр оруулж байна.

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

- Ерөнхий суурь хичээл **37 \30,5%**багц цаг байна.
- Мэргэжлийн суурь хичээл **9\7,4%** багц цаг байна.
- Мэргэжлийн заавал судлах **54.\49,5**багц цаг байна.
- Мэргэжлийн сонгон судлах **6**
- Чөлөөт сонголт **15\12,4%** багш цаг байна.
- Нийт **121** цагийн багтаамжтай.

Хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг багш нарын эрдмийн зэрэг

Багшийн эрдмийн зэрэг	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
Магистр	-	1	2	2	-
Доктор	7	7	7	7	8

Хөтөлбөрийн нэг багшид ноогдох оюутны тоо

Багш, оюутны тоо	2017-2018	2019-20119	2019-2020	2020-2021	2021-2022
------------------	-----------	------------	-----------	-----------	-----------

Багшийн тоо	10	10	11	11	9
Оюутны тоо	56	51	63	76	65
Нэг багшид ноогдох оюутны тоо	1:5.6	1:5.1	1:6.9	1:8.4	1:5.8

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

2011 онд батлагдсан МУИС-ийн “Стратегийн төлөвлөгөө”-нд туссан зорилтын 2.1-д заасан “Олон улсын стандартад нийцүүлж сургалтын тогтолцоог шинэчлэх” заалтын үндсэн дээр МУИС-ийн захирлын 2014 оны А\259 тоот тушаалаар анх баталж мөрдөж байсныг 2017 оны 10-р сарын 26, 2019 оны 10-р сарын 24, 2020 оны 6-р сарын 11-ны МУИС-ийн ШУС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцэж тус тус өөрчлөлт оруулж сайжруулан мөрдөж ажиллаж байна.

Онцлог зүйл:

Төгсөгчийн ирээдүйн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн судалгаа хийж утга зохиол судлаач-сэтгүүлч давхар мэргэжлээр ажиллах чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэхэд зориулан, хөтөлбөрөө сайжруулж, олон улсын болон дотоодын нэр хүнд бүхий АНУ-ын Йель Их сургууль, Хонкогийн Их сургууль, СУИС зэрэг их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулан үнэлгээ өгч, хөтөлбөрийн агуулга, багц цагийн тооцоог гаргасан

Зөвлөмж:

- Уг хөтөлбөрөөр төгсөгчдийн ихэнх нь сэтгүүлч, редактораар ажлын байраа олж байгааг анхаарч, үндсэн судлаач мэргэжлээр ажиллах мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн дотоод зохицуулалт хийх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн сургалтын төлөвлөгөөг зохих шаардлагын дагуу хэлэлцэж, тэмдэглэл хөтлөн, баталж мөрдөж, цаг хугацаа, нийгмийн шаардлагад нийцүүлэн өөрчлөн сайжруулан МУИС-ийн захирлын 2015 оны 6-р сарын 30-ны өдрийн тушаалаар батлагдсан сургалтын журмын 3.6.2-т зааснаар а) ерөнхий суурь 36, б) мэргэжлийн суурь 9, в) мэргэжлийн 60, г) чөлөөт сонголт 15 багц цагийн хичээлийг төлөвлөн ажиллаж байна. Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, багш нарын нарийн мэргэжил, хөтөлбөрийн агуулгыг харгалзан 2018-2021 онуудад хөтөлбөрийг сайжруулан өөрчилснөөр 2018 онд 129, 2019 онд 122, 2020 онд 126, 2021 онд 123 багц цагийг тусган төгсөлт хийсэн байна.

Онцлог зүйл:

2016-2021 оны төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг 2021 оны 11р сард хийхэд судалгаанд оролцогчдын 78,9 хувь нь хөтөлбөрийн агуулгад сэтгэл ханамжтай, 19,2 хувь нь тодорхой хариулт өгөөгүй, 1,9 хувь нь сэтгэл ханамжгүй гэсэн үзүүлэлт гарсан нь хөтөлбөрийн чанарын үзүүлэлт зах зээлийн эрэлтэд нийцэж байна гэж үзэх бүрэн үндэстэй.

Анхаарах асуудал:

- Ихэнх төгсөгчид сэтгүүлчээр ажиллаж байгаа үед, төрийн албаны шаардлагын дагуу зөвхөн сэтгүүлч мэргэжлийн индекстэй боловсон хүчнийг ажилд авч байгаа нөхцөл байдалд уялдуулан, хөтөлбөрт сэтгүүл зүйн хичээлийг зохих харьцаагаар оруулах;

Зөвлөмж:

- Төрийн албанд зөвхөн сэтгүүлч мэргэжлийн индекс бүхий дипломтой боловсон хүчнийг шалгаруулан авч буй тул, төгсөлтийн дараа юмуу төгсөх ангийн оюутнуудад сертификатын сургалт зохион байгуулах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрөө төлөвлөхдөө Боловсролын тухай хуулиуд, БШУС-ын яамнаас гаргасан тогтоол шийдвэрүүд, МУИС-аас гаргасан дүрэм журмууд, Сургуулийн хөтөлбөрийн хорооноос гаргасан нийтдээ 16 эх сурвалжид тулгуурлан хөтөлбөрөө төлөвлөн боловсруулжээ. Хөтөлбөр нь МУИС-ийн либерал арт хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн учир ерөнхий болон мэргэжлийн суурь хичээлүүдээс сонголт хийх боломж өргөн болсон.

Онцлог зүйл:

Хөтөлбөр нь заавал үзэх хичээлээс гадна, сонгох, чөлөөт сонгох хичээлүүдтэй байгаа нь мэргэжлийн хувьд гүнзгийрүүлэн сурах, өөр мэргэжлээр хос болон давхар боловсролтой болж төгсөх боломжийг хадгалсан.

МУИС-ийн сургалтын журам, Хавсарга хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх журам, сургалтын бодлогын хүрээнд чөлөөт сонголтын хичээлээр хавсарга болон хос мэргэжлээр суралцаж авсан багц цагаа магистрын зэрэгцсэн хөтөлбөрийн багц цагт тооцуулах боломжтой.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр нь төгсөгчийн эрх ашгийг бодож, ажилтай болгох талыг илүүд үзэж байгаагаас үндсэн судлаач мэргэжлээр ажиллах мэргэжилтэн бэлтгэх тал дээр анхаарах;

Зөвлөмж:

- Утга зохиол судлаачийг гүнзгийрүүлэн мэргэшүүлэхэд хөтөлбөр нь боломжтой боловч багш нарын оролцоо, идэвхийг нэмэгдүүлж сонгох болон чөлөөт сонголтын хичээлд утга зохиолын гүнзгийрүүлсэн хичээлийг үзэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Утга зохиолын мэргэжлийн дээд боловсролын стандартыг баримтлан агуулгаа бүрдүүлсэн. Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь: Заавал үзэх, сонгон үзэх, мэргэжлийн: заавал үзэх, сонгон үзэх, Сонгон судлах хичээлүүдийн багтаамжийг зөв зүйтэй тооцоолон оруулсан. Түүнчлэн чөлөөт сонголтын 15 багцыг олгосоноор хос болон давхар мэргэжил эзэмших боломжийг бүрдүүлсэн.

Ингэхдээ хичээл хоорондын уялдаа холбоог хөнгөнөөс хүнд рүү, шинжлэх ухаан хоорондын уулзвар заагыг зөв оновчтой шийдэж хөтөлбөртөө тусган мөрдөж байгаа. Нийтдээ 120-оос доошгүй багц цагийг чөлөөтэй тавьж өгснөөр оюутнууд өөрсдийн сонголтоор нэмэлт багц цаг үзэж мэргэжлийн хамрах хүрээг өргөтгөх боломжийг бүрдүүлж өгсөн.

Онцлог зүйл:

Хөтөлбөрийг сайжруулах зорилгоор төгсөгчдөөс судалгаа авч, саналын үндсэн дээр “Ялангуяа мэргэжлийн хичээлийг нэмэгдүүлэх, шүүмж судлал болон уран зохиолын түүхийн хичээлийг нэмэгдүүлж, редакторлах арга зүйтэй холбоотой

хичээлийн цагийг нэмэх хэрэгтэй гэж үзсэн”. Төгсөгчдөөс авсан судалгааг хөтөлбөрийг сайжруулах үндсэн гол баримт бичиг болох тал дээр илүү анхаарч байгаа.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, мэдээлэл харилцааны дэвшилтэт технологийг ашигладаг байна гэдэг шалгуурын доор хөтөлбөрийн бүтэц нь лекц 22%, семинар 19%, дадлага 3%, бие даалт 54% байгааг суралцагчдын өнөөгийн ухамсар, нийгэмшил, идэвхтэй холбон өөрчилж болох эсэх. Дадлагын эзлэх хувь хэт бага, бие даалт хэт их байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хорооноос тавьж буй шаардлагад нийцүүлэн шалгалтын асуулт даалгаврын түвшинг тогтоох санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх үнэлэх бүтээх гэх мэтчилэн хувааж авч байгааг утга зохиол гэх сэтгэлийг, мэдрэмжийг үнэлэх үнэлэлт болж чадаж байгаа эсэх дээр анхаарч мэргэжлийн онцлогийг харгалзан үзэх үнэлгээний шалгуурыг нэмэх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтад ашиглаж буй арга зүй нь суралцагчийн шүүмжлэлт сэтгэл зүйг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачилга бий болгох, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй илэрхийлэх, онолын мэдлэгийг амьдралын бодит үйл ажиллагаанд хэрэглэх ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн.

Онцлог зүйл:

Утга зохиол судлалын хөтөлбөрийн төгсөгчийн загварыг гаргаж, хөтөлбөрийн загварт багтсан 5 чиглэлийн ур чадвартай мэргэжилтнийг бэлтгэхэд хичээл тус бүр ямар хувь нэмэртэй байгааг тодорхойлсон. Тухайлбал. Утга зохиолын судлаач, утга зохиолын ажилтан, уран сайхны редактор, зохиолч, уран зохиолын багш. Тус бүр дээр чөлөөт сонголтын хичээлийг үзэж тухайн мэргэжилтэн болж болно.

Анхаарах асуудал:

- Дадлагын хичээлийг ганц удаа, зөвхөн сэтгүүлчийн мэргэжлээр хийж буй нь үндсэн утга зохиол судлалаас гэсэн мэргэжлээр төгсөж суралцагчдад хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Утга зохиол судлаач, сэтгүүлч гэсэн хоёр үндсэн мэргэжил дээр хөтөлбөрийн гол ачааллыг тохируулан ажиллах;
- Утга зохиол судлал хичээлээр заавал дадлага хийлгэх.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

МУИС-ийн үнэлгээний нийтлэг журмыг ашигладаг, нэмэлт үнэлгээний тэмдэглэгээг зохих ёстой үед нь хэрэглэдэг гэж тайланд бичсэн нь өнөөгийн монголын дээд боловсролын оюутныг үнэлэх нийтлэг зарчим, шалгуурт нийцэж байна.

Онцлог зүйл:

Хичээлийн тодорхойлолтод ерөнхий болон сэдэв бүрээр эзэмших мэдлэг чадвар дадал, улирлын явцын болон эцсийн шалгалтын оноог хэрхэн үнэлэхээ нарийвчлан заасан байдаг. Түүнчлэн багш тухайн улирлын эхэнд хичээлийн үнэлгээ задаргааг суралцагчдад танилцуулдаг.

Анхаарах асуудал:

- Утга зохиол гэдэг судлагдахуун өөрөө сэтгэл мэдрэмжийн учир энэ тал дээр үнэлгээний эдгээр аргууд яг тохирч буй эсэх дээр эргэж харах;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хорооноос тавьж буй шаардлагад нийцүүлэн шалгалтын асуулт даалгаврын түвшинг тогтоох санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх үнэлэх бүтээх гэх мэтчилэн хувааж авч байгааг утга зохиол судлал шинжлэх ухааны аргатай уялдаа холбоотойгоор өөрчлөх;. Өөрөөр хэлбэл бүтээлч сэтгэлгээг илүүд үзэх тал дээр шалгалтын арга зүйг боловсруулах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Тус хөтөлбөрөөр суралцаж буй оюутны тоотой харьцуулахад анги танхим хүрэлцээтэй /харьцангуй цөөн хүүхэдтэй буюу 1-р курс /ерөнхий суурь/, 2-р курс 11, 3-р курс 12, 4-р курс 19 / буюу тэнхимийн мэдлийн 4, бусад тэнхимтэй хамтарсан 2 нийт 6 ангитай байна. Үүнд: № 335, 342, 340, 339 тоот ангиуд багтах бөгөөд №335 анги ухаалаг дэлгэцтэй, № 342, 340, 339 тоот ангиуд суурин проектортой. 335, 342 ангиуд утастай интернэтэд холбогддог бол 339, 340 ангиуд МУИС-ийн дотоод утасгүй сүлжээ болох NUM-аар холбогддог нь “Утга зохиол судлал” D023203 хөтөлбөр үр дүнтэй хэрэгжих боломж байна. Интернэт нь богино хэмжээний youtube бичлэгийг гацахгүй үзэх боломжтой.

Багш нарт интерактив хичээл явуулах боломж бүхий бүрэн тоноглогдсон бичлэгийн студитэй. Түүнд Д.Галбаатар, Г.Нарантунгалаг багш нарын “Уран зохиол шинжлэлийн удиртгал”, Г. Галбаяр “Монголын орчин үеийн уран зохиол” бүрэн 2 лекцийг бичүүлэх захиалга өгсөн байгаа нь цахим хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн байна. Багш нар нь урлаг судлалын багш нарын хамт 2 өрөөнд хуваагдаж суудаг бөгөөд бүх багш нарын компьютер болон принтерийг 5 жил тутамд шинэчилдэг. 3,4 давхарын коридорт оюутны бие даан суралцахад чиглэгдсэн нийт 3 хэсэг сандал ширээ бүхий хэсэг байдаг бөгөөд энэ нь номын сан дүүрэн байх үед болон хичээлийн богино завсарлагуудаар амрах, хичээлээ давтах боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Онцлог зүйл:

Хичээлийн анги танхим хүрэлцээтэй /48 суралцагчид 6 анги/. Бүгд интернэтэд холбогдсон бөгөөд ухаалаг дэлгэц, ухаалаг индэр, проектортой.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжиж буй орчин болох 1 болон 2-р байранд хоолны газар байхгүй, жижигхэн буфет ажилладаг нь оюутны сурах орчин, амралт, цагийн менежмент, эрүүл зөв хооллох зэрэгт сөрөг нөлөөтэй тул суралцах орчин бүрдүүлэхэд анхаарах;
- Их завсарлагагүй шууд хичээллэдэг нь олон цагийн хичээлтэй өдрүүдэд суралцагчдад хүндрэлтэй байдгийг анхаарах;
- Ангиудад агааржуулах систем байхгүй тул халууцах, бүгчимдэх зэрэг хүндрэл бий болдог, цонх онгойлгохоор авто замын чимээ шуугиан ихтэй байгааг анхаарах;
- Оюутны вэб болох Си Си системийн хичээл сонголт хийх, хичээлийн хуваарь сонгох, дүн гарах зэрэг улирлын эхэн болон сүүл үед гацдаг, хурд удааширдаг байдлыг анхаарах;

Зөвлөмж:

- Оюутны хоолны газар сургуулийн орчинд нээх;
- Ангиудад агааржуулалтын систем суурилуулах;
- Үдийн их завсарлагаатай болгох;
- Си Си системийг илүү сайжруулах зэрэг асуудлыг бүрэлдэхүүн сургууль болон төв сургуульдаа хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Нийт заавал судлах хичээлийн 12 сурах бичиг, 13 гарын авлага, 12 нэг сэдэвт бүтээл, 2 орчуулгын бүтээл байна. Эдгээрээс 7 сурах бичиг, 7 гарын авлага, 5 нэг сэдэвт бүтээлийг тус тус сүүлийн 5 жилд бичиж шинэчлэгджээ. Цахим хичээлд үндсэн 5 багш цахим сургалтын 153 цагийн материалтай байна. Үүнд:

- Г.Нандинбилэг 3 хичээлийн /заавал судлах “Монгол ардын аман зохиол” 3 кр, сонгон судлах “Уран зохиолын дидактик” 3 кр, ерөнхий суурьт судлах “Монгол соёл иргэншил” 3 кр/ нийт 48 цагийн цахим хичээл teams дээр байршсан.

- Б. Хишигсүх 4 хичээлийн /заавал судлах “Монголын эртний уран зохиол” 3кр, “Илтгэх урлаг” 3 кр, “Туурвилзүй” 3 кр, сонгон судлах “Кино судлал” 2 кр/ 24 цагийн хичээл Power point хэлбэр, 12 цагийн хичээл видео бичлэг хэлбэртэй байна.
- Г. Галбаяр багшийн 3 хичээл 80 цагийн лекц 64 цагийн семинар Power point хэлбэрээр байна.
- С. Дашдэжид багшийн 4 хичээлийн /заавал судлах “Дорно дахины уран зохиол” 3 кр, сонгон судлах “Уран зохиолын найруулга зүй” 2 кр, “Уран зохиолын эх судлал” 2 кр/ нийт 48 цагийн лекц уоотube дээр байршсан.
- Г.Нарантунгалаг багшийн 3 хичээлийн \заавал судлах “Уран зохиол шинжлэлийн удиртгал” 3 кр, “Уран сайхны шүүмжлэлийн онол, арга зүй” 3 кр, сонгон судлахын “Монголын уран зохиолын судлал шүүмжлэлийн түүхэн тойм” 3 кр\ 45 лекц, семинар уоотube дээр байршсан. Teams, Forms программаар шалгалтаа авч байна.

Онцлог зүйл:

Нийт 12 сурах бичиг 13 гарын авлага нь бүгд салбартаа өндөрт үнэлэгддэг нэр хүнд бүхий ахмад багш судлаачдын /С.Дулам, Д.Галбаатар, Д.Батжаргал, Г.Нандинбилэг гэх мэт/ бүтээл туурвилыг хичээл сургалтад шууд ашиглаж байгаа нь давуу тал болж байна. Мөн багш нар Teams, Forms зэрэг программаар хослуулан шалгалтаа авч байна. Office 365 цахим шуудангийн үйлчилгээг Си Си мэдээллийн системтэйгээ холбож оюутан бүрд цахим шуудангийн хаяг үүсгэж хэрэглээнд нэвтрүүлэн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Номын сан дахь утга зохиолын номын тасгийг сүүлийн үеийн зохиолуудаар баяжуулж, эх зохиолын сан бүрдүүлэх;
- Тэнхимд байрлах номын санг эх зохиол болон судлал шүүмжийн бүтээлүүдээр баяжуулах;

Зөвлөмж:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, эх зохиолын хангамжийг сайжруулах;
- Утга зохиол урлаг сонин болон Цог сэтгүүлийг тэнхимийн номын санд байнгын хэрэглээтэйгээр байрлуулах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Сургуулийн номын сан нь 2017 онд ашиглалтад орсон. Орчин үеийн интерьерийн шийдэл бүхий 15 салбарт 700 гаруй суудалтайгаар үйлчилгээ үзүүлдэг. 39000 гаруй хэвлэмэл болон цахим номтой. МУ-ын анхны 24 цагийн үйлчилгээтэй номын сан гэдгээрээ давуу талтай. Орчин нөхцөл, үйлчилгээ, дэвшилтэт технологи зэргээрээ олон улсын жишигт нийцэхүйц. Ховор номын фонд болон цахим номын сангийн үйлчилгээ үзүүлдэг суралцагчийн ая тухыг бүрэн хангасан. Тусдаа утга зохиолын номын тасагтай. Уран зохиолын бүх төрлүүдээр төрөлжүүлэн катологижсон. Онлайн хайлтын систем болох catalog.num.edu.mn-ээр 23600 сурах бичиг, 6643 магистрын дипломын ажил, 738

докторын ажил, 5000 гаруй эрдэм шинжилгээний сэтгүүлийг үзэж, захиалж болж байна. Номын сан сүүлийн 5 жилд 8986 төрлийн 37615 тоо ширхэг номыг хандив, төсөл, худалдан авах хэлбэрээр авч номын фондоо баяжуулсан байна. Цахим номын сангаар сүүлийн 5 жилд 1275596 хандалт хийгджээ. 2016 онд 11284 хандалт байсан бол 2020 онд 345110 болж өссөн нь тус номын сангийн цахим үйлчилгээний өсөлтийг харуулж байна.

Гадаадын онлайн сан болох EBSCO, Springer, Jstor зэргийг 2017 онд 9142, 2018 онд 10844, 2019 онд 14055, 2020 онд 26388 удаа буюу нийт 60429 удаа ашигласан байна. Сүүлийн 5 жилд өссөн үзүүлэгтэй гарчээ. Утга зохиолын тэнхим өөрийн гэсэн номын сантай бөгөөд тус хөтөлбөрийн чиглэлийн 225 ном, 183 дипломын ажилтай.

Онцлог зүйл:

24 цагийн үйлчилгээ үзүүлдэг 700 хүний суудал 39000 хэвлэмэл ном бүхий олон улсын жишигт нийцсэн номын сантай. Магистрын судалгааны бүтээлүүдийг 100 хувь, докторын судалгааны ажлыг 80 хувь цахим бүртгэлд оруулсан. Номын сан бүхэлдээ утасгүй сүлжээнд хамрагдсан.

Анхаарах асуудал:

- Эртний судар болон монгол бичиг дээрх номуудаар номын сангаа баяжуулах;
- Төрөл зүйл, тоог нэмэгдүүлэх;

Зөвлөмж:

- Мэргэжлийн бусад байгууллагуудтай /МУБИС, Хэл зохиолын хүрээлэн, Улаанбаатар ИС гэх мэт/ илүүтэй хамтран ажиллаж ном, судалгааны бүтээлээ солилцох, баяжуулахад чиглэсэн янз бүрийн жижиг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
- Аль нэг тохиромжтой танхимыг уламжлалт “Утга зохиолын нэгдэл”, утга соёлын “Өлзий” нэгдэл мөн түүнчлэн эх бичиг, сурвалж судалгааны кабинет танхим бүрдүүлэх, шаардлагатай дуу бичлэгийн тоног төхөөрөмжөөр тохижуулах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо

Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн хөтөлбөрийн хороо нь ШУС-ийн бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд 7 хүний бүрэлдэхүүнтэй. МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмын 4.3 болон 4.15-д тэнхимийн хөтөлбөрийн хорооны ахлагч тухайн

тэнхимийн эрхлэгч байна гэж заасан байдаг. 2014 оноос хойш УЗУСТ-ийн тэнхимийн эрхлэгч солигдсонтой холбоотой хөтөлбөрийн хорооны ахлагч 4 удаа солигдсон ба сүүлд ШУС-ийн захирлын 2017 оны 04 сарын 18 өдрийн Б/73 тушаалаар тэнхимийн хөтөлбөрийн хорооны даргаар проф. Г.Нандинбилиг томилогдон ажиллаж байна.

Утга зохиол судлалын хөтөлбөрийн дэд хороо нь сүүлийн 3 хичээлийн жилд 10 удаа хуралдаж сургалтын хөтөлбөрийг сайжруулах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэжээ. 2015 онд Утга зохиол судлал бакалаврын хөтөлбөрийг мэргэжлийн чиглэл, индекс, бакалаврын хөтөлбөр боловсруулах удирдамжийн дагуу боловсруулан шат шатны хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлэн батлуулсан. 2021 онд зарим хичээлийн хөтөлбөрт шинэчлэл хийжээ.

Онцлог зүйл:

Тайлангийн хугацаанд эрдмийн зэрэгтэй багшийн тоо нэмэгдсэнтэй холбоотой ШУС-ийн захирлын 2018 оны 01 сарын 26 өдрийн Б/76, 2018 оны 09 сарын 24 өдрийн Б/141, 2020 оны 4 сарын 24-ны Б/38 тоот тушаалаар УЗУСТ-ийн хөтөлбөрийн хороог тус тус өргөтгөсөн байна. Утга зохиол судлал хөтөлбөрийн багш, оюутан суралцагчид СиСи мэдээллийн системийг сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд өргөн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- 2020-2021 оны хичээлийн жилээс хөтөлбөрт элсэгчдийн тоо буурах үзэгдэл ажиглагдсан тул хөдөлмөрийн зах зээлд нийлүүлж буй мэргэжилтнийхээ мэдлэг ур чадварт анализ хийх, төгсөгчдийн загвараа сайжруулах тал дээр анхаарч, багш бүрт өөрийн хичээлийг суралцахуйн үр дүнд тулгуурлан боловсруулж, агуулга арга зүй, хэрэглэгдэхүүнээ шинэчлэн сайжруулах даалгавар өгсөн бөгөөд энэ ажил одоо үргэлжилж байгаа үйл явцыг цаг үетэйгээ нийцүүлж хурдавчлах;
- Багш нар хичээлийн хөтөлбөрөө тогтмол шинэчлэх, өгсөн загварт хэтэрхий баригдахгүй байх;
- Хөтөлбөрийн стратеги төлөвлөлтийн дагуу улирлын жилийн дунд хугацааны явцын тайланг гарган шинжилгээ хийж хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байх;
- Оюутан суралцагчдаас авдаг сэтгэл ханамжийн судалгаа нь зөвхөн багшийн үйл ажиллагаанд голлосон бус хөтөлбөрийг сайжруулахад чиглэсэн олон хувилбарт асуулгаар баяжуулах хэрэгтэй.

Зөвлөмж:

Утга зохиол судлалын хөтөлбөрийн хорооны багш нар нь МУИС-ийн стратегийн төлөвлөгөөний 2-р үзүүлэлтийн “Сурах- сургах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” зорилтуудыг биелүүлэх тухайд харьцангуй амжилттай байгаа ч 1-р үзүүлэлтийн “Судалгааны чанар, хамрах хүрээг дэлхийн түвшинд хүргэх” зорилтыг хангаж ажиллах тухайд учир дутагдалтай байгаадаа дүгнэлт хийж ажиллах, сайжруулах төлөвлөлт хийх;

- Тэнхим хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гаргаж, цаашдын зорилтоо тодорхойлох;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлуудын тайлан, үр дүнг нарийн тооцоог маркетингийн үйл ажиллагаанд хэрэглэх;
- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл, хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлт, сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналтын талаар тайланд оруулж дүгнэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

МУИС нь 2018-2024 оны Стратеги төлөвлөгөөний дагуу олон улсын болон дотоодын их дээд сургууль, байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхээр тогтмол анхаарч ирсэн бөгөөд 2020 оны байдлаар дэлхийн 36 улсын 217 их дээд сургууль, бизнесийн болон бусад чиглэлийн байгууллага, дотоодын 54 их дээд сургууль, байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг үзэглэн ажиллаж байна. Үүнээс гадна хурал арга хэмжээнд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, туршлага солилцох, төслийн уулзалтад оролцох зорилгоор 19 улсад 36 хүн томилогдон ажиллаж, дээрх зорилгоор гадаадын 17 улсын 55 зочин МУИС-д айлчилсан байна.

Утга зохиол судлал хөтөлбөрийн багш нар 2016-2021 онд төрийн болон төрийн бус байгууллага, дотоодын их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний 3 төслийг удирдан ажиллаж, ерөнхий суурь ба мэргэжлийн суурь хичээлүүдээр сурах бичиг зохиох 3 төслийг дэвшүүлж, нийт 6 төсөл хэрэгжүүлэхийн хамтаар олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 3 удаа зохион байгуулсан байна. Үүнд:

- ✓ 2017-2018 онд “Монголын цагаан сарын соёлын өөрчлөлтийн судалгаа” төсөл,
- ✓ 2019-2020 онд “Монгол үндэсний ижилсэл-ондоошлын судалгаа” төсөл,
- ✓ 2019-2021 онд “Монголын уран зохиолын дурсгал “Гэсэр”-ийн судалгаа” төсөл,
- ✓ 2020-2022 онд “Түүхэн сурвалжаар уламжилсан түүх домгийн судалгаа” зэрэг сэдвүүдээр эрдэм шинжилгээний 3 төслийг удирдах буюу оролцон ажиллаж, судалгааны тайлан, өгүүлэл хэвлүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулсан байна.
- ✓ 2016-2017 онд “Илтгэх урлаг” ерөнхий суурь хичээлийн сурах бичиг зохиох төсөл
- ✓ 2019-2020 онд “Монгол соёл иргэншил” ерөнхий суурийн хичээлийн сурах бичиг зохиох төсөл
- ✓ 2019-2020 онд “Монголын эртний уран зохиол” мэргэжлийн заавал судлах хичээлийн сурах бичиг зохиох төсөл
- ✓ 2016 оноос хойш Утга зохиол судлал хөтөлбөрт суралцаж буй суралцагчдаас нийт 11 оюутан 102 739 000 төгрөгийг тэтгэлэг авсан байна. Хөтөлбөрийн төгсөгч Э.Энхсаруул суралцаж байх хугацаанд А.М.Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургуулийн уралдаант шалгаруулалтад тэнцэж, 91 618 000 төгрөгийн тэтгэлэг авчээ. Мөн хөтөлбөрийн оюутнууд УИХ-ын гишүүн, аймгийн Засаг дарга болон бусад байгууллагын тэтгэлэгт хамрагдахаас гадна багш нар нь Антоон Мостаэрт Монгол Судлалын төвтэй нягт хамтран ажиллаж, “Оюутан судлаач” тэтгэлэгт хөтөлбөрт жил бүр Утга зохиол судлал хөтөлбөрийн оюутнуудыг хамруулдаг. Антоон Мостаэрт Монгол Судлалын төв нь тухайн хөтөлбөрт хамрагдаж буй оюутнуудад улирал бүр мөнгөн урамшуулал, тэтгэлэг олгодог бөгөөд 2016-2022 онуудад 19 оюутан 4560000 төгрөгийн мөнгөн тэтгэлэг авчээ.

Онцлог зүйл:

УЗУСТ нь Бээжингийн Төвийн үндэстний их сургууль, Өвөрмонголын Их сургуультай олон жилийн хамтын ажиллагаатай явж ирсэн бөгөөд тайлангийн хугацаанд хамтран ажиллах гэрээгээ шинэтгэн сунгасан ба ОХУ-ын Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургуультай хамтран ажиллах санамж бичгийг шинээр байгуулсан байна.

Хөтөлбөрийн багш нар Монголын зохиолчдын эвлэл, Монголын үндэсний чөлөөт зохиолчдын холбоо, СУИС-ийн Театр урлагийн сургууль, МУБИС-ийн Уран зохиолын тэнхим, БСШУЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт зэрэг дотоодын их дээд сургууль, төрийн бус байгууллагатай хамтран судалгаа шинжилгээ, сургалт семинар, соёл урлагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах ажлуудыг хийж, орон нутгийн сургууль, соёлын төвийн номын санд ном бүтээлийн дээжээ хандивлаж, нийгэмд чиглэсэн олон талт ажлуудад оролцож ирсэн.

Оюутанд чиглэсэн хөтөлбөрийн үйл ажиллагааг өргөжүүлэн, уран зохиол яруу найрагт авьяастай оюутнуудад зориулсан Утга зохиолын нэгдэл, судлаач оюутны “Өлзий” нэгдэл зэрэг оюутны клубүүдээр дамжуулан мэргэжлээ сурталчлах, мэргэжлээрээ бахархах, авьяас сонирхлоо хөгжүүлэн суралцах боломжоор хангаж байна. Тухайлбал, 2015-2022 онд багш Д.Цэнджав, Д.Нямдорж, туслах ажилтан И.Даваадорж нар Утга зохиолын нэгдлийн үйл ажиллагааг удирдан зөвлөх багшаар тус тус ажиллаж байна.

2021 оны байдлаар МУИС-ийн Утга зохиол судлалын хөтөлбөрөөр нийт 272 утга зохиол судлаач бэлтгэгдэж төгссөн байна. 2021 онд авсан судалгаанаас үзэхэд 2016-2021 оны төгсөгчдийн 98.1 хувь нь хөдөлмөр эрхэлж, төрийн ба төрийн бус байгууллага, их дээд сургууль, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаагаас 31 хувь нь Утга зохиол судлаач, редактор мэргэжлээрээ ажиллаж байна. Төгсөгчдийн зарим нь чөлөөт уран бүтээлчид болж, зохиол бүтээл туурвин, мэргэжлийн үүргээ биелүүлж байгаа бол зарим нь ерөнхий ур чадвараараа мэргэжлийн бус ажил хийж байгаа нь ажиглагдлаа.

Анхаарах асуудал:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан, багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам, нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/, төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал, төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээллийг баримт нотолгоотой тайланд бүрэн тусгах, үр дүнг тооцох;
- Төгсөгчдийн холбооны ажлыг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг гаргадаг байх, тэнхимийн элсэлт, хөгжлийн бодлогод нөлөөлдөг чухал хөшүүрэг болгож, шинэ шатанд гаргах, түүнчлэн хөтөлбөрийг сайжруулах ажлынхаа нэг чухал хэсэг болгоход анхаарах;
- Хамтын ажиллагаа болон төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг нарийн тооцож үр ашгийг оновчтой ашиглахад анхаарах;

Зөвлөмж:

- Гадаадын их, дээд, сургууль байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлж буй үр дүнгийн шинжилгээг хийдэг байх;
- Төгсөгчдөд чиглэсэн үйл ажиллагааг системтэйгээр төлөвлөх, тогтмолжуулах;
- Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, нийгэмд байгаа бодит асуудлуудыг шийдэхэд багш, оюутнуудыг татан оролцуулах талд анхаарах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Утга зохиол судлал хөтөлбөрийн 2020 оны нийт зардлын 91.6 хувийг багш ажилтны цалин хөлс, 4.2 хувийг тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын зардал, 0.78 хувийг хичээл практикийн зардалд, 2.8 хувийг бусад буюу бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, төлбөр 60.2 38.5 1% Утга зохиол судлал хөтөлбөрийн орлого (2019, 2020) дотоодын суралцагч, гадаадын суралцагч, тэтгэлэг 83 хураамж зэрэгт зарцуулжээ.

Утга зохиол судлал хөтөлбөрийн 2020 оны нийт зардлын 91.6 хувийг багш ажилтны цалин хөлс, 4.2 хувийг тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын зардал, 0.78 хувийг хичээл практикийн зардалд, 2.8 хувийг бусад буюу бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, төлбөр 60.2 38.5 1% Утга зохиол судлал хөтөлбөрийн орлого (2019, 2020) дотоодын суралцагч, гадаадын суралцагч, тэтгэлэг 83 хураамж зэрэгт зарцуулжээ. Үүнээс харахад нэг оюутны төлбөрийн олонх хувь нь зөвхөн цалин хөлсөнд зарцуулагдаж байгаа бөгөөд сургалтын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын зардал ихээхэн бага байгаад цаашид дүгнэлт хийж, ажиллахаар зорьж байна.

Утга зохиол судлал хөтөлбөрийн багш нарын анги танхимыг тохижуулах, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан, 2019 онд 8 278 010 төгрөгийг тоног төхөөрөмж, 2020 онд 5 642 256 төгрөгийг тавилга эд хогшил, 6 804 759 төгрөгийг тоног төхөөрөмжид захиран зарцуулсан байна. Утга зохиол судлал хөтөлбөрийн профессор, багш нар сүүлийн 5 жилд 102 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл хэрэгжүүлсэн байна. Төслийн санхүүжилтээр оюутанд сургалтын төлбөр өгөх, судлаачаар ажиллуулах, тоног төхөөрөмж худалдан авах зэргээр хөтөлбөрийн сургалт, судалгааны үйл ажиллагаанд хувь нэмэр оруулдаг.

Тус сургууль нь бүс нутаг, орон нутгийн шинжтэй захиалгат болон суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, суралцагчдын төлбөр, төсвийн орлогоос хуримтлалын сан бүрдүүлэх, үндсэн буюу үйл ажиллагааны гэх мэт орлогын эх үүсвэр олохын төлөө ажилладаг. Оюутнуудын сургалтын төлбөрийг ашигтай зүйлд зарцуулж, үргүй зардлыг багасгаж оюутанд үзүүлэх үйлчилгээний чанар, үр ашигт анхаарч ирсэн.

Жил бүр оюутанд үзүүлэх үйлчилгээний зардал өсөж байгаа боловч оюутны сургалтын төлбөр харьцангуй тогтвортой хэмжээнд байна. Сургалтын төлбөрийг зарцуулахдаа дараах загварыг баримталдаг. Үүнд :100% = Хөрөнгө оруулалт /4.5%/ + Тогтмол зардал /4.5%/ + Багшийн цалин /65-70%/ + Эрдэм шинжилгээний зардал /2.5%/ + Оюутны арга хэмжээний зардал /1.2%/+Бараа үйлчилгээтэй зардал /18.8%/ + Бусад зардал /1%/ байгаа бөгөөд 2015-2020 оны ХЗТ-ийн төсөв зардлыг харахад багшийн цалин хөлс,

илүү цагийн хөлс, багшийн мэргэжил дээшлүүлэх зардал (600,0-1638,0). эрдэм шинжилгээний зардал (900,0- 1361,0), ном хэвлэлийн зардал (900,0-6202,0) тогтвортой өсөн нэмэгдсэн. Мөн лаборатори дадлагын хичээлийн зарцуулагдах зардал 2015 оныхтой харьцуулахад 10 дахин өссөн. х-81.

Тэнхим үндсэн үйл ажиллагаанаас гадна багш нарын төрөлжсөн болон кредиттэй сургалтыг зохион байгуулах, Бүс нутаг, орон нутгийн шинжтэй захиалгат болон суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаагаар орлого олох боломжтой.

Онцлог зүйл:

МУИС-ийн ШУС-ийн Захирлын тушаалаар сүүлийн таван жил 24 700 000 төгрөгийг багш ажилтныг дэмжих зардалд гаргасан бөгөөд уг мөнгөөр хөтөлбөрийн багш нар эрдэм 85 шинжилгээний хурал зохион байгуулах, ном бүтээлээ хэвлүүлэх, шаардлагатай техник хэрэгсэл авахад зарцуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн нийт орлого 494 338 060, зарлага 579 827 583 байгаад анхаарч бодитой тооцоо судалгаа, дүгнэлт хийх;
- Хөтөлбөрийн хөгжил, үр дүнд суурилсан хөтөлбөрийн шинэчлэл өөрчлөлтөд чиглэсэн төсвийн талаарх мэдээлийг цаашид тодорхой болгох;
- Нийт сургуулийн хэмжээнд оюутны арга хэмжээний нийт зардлын 1,2 хувийг эзэлж байгаад анхаарах;
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг санхүүжилтийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн нэгжээс бусад эх үүсвэрээс олж буй орлого, түүний тайланг тодорхой гарган дүгнэж ажлаа төлөвлөдөг байх;
- Өөрсдийн сургалт, судалгааны ажил, төсөл, хөтөлбөрөөс олох орлогыг нэмэгдүүлж, санхүүгийн тооцоог нарийвчлан төлөвлөх замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах санхүүгийн олон эх үүсвэртэй болоход анхааран ажиллах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

МУИС-ийн элсэлтийн үйл ажиллагааг таниулах үед бүрэлдэхүүн сургуулиуд дээр хэрэгжүүлж буй мэргэжлийн хөтөлбөрүүдийн талаар товч мэдээллийг Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчид, эцэг эхчүүдэд хүргэдэг. Мэдээллийг хэвлэмэл материал, видео танилцуулга байдлаар Сургалтын нэгдсэн албанаас бэлтгэж БШУЯ, Аймаг орон нутгийн удирдлагууд, ТББ зэргээр дамжуулан хүргэдэг. Энэ үйл ажиллагааг 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн жил бүрийн хавар тогтмол явуулж ирсэн. Профессорын өв цувралаар 2 багшийн 6 боть ном хэвлүүлж, МУИС-ийн Алтан сан, цуврал лекцүүдийг олон нийтэд зориулан цахим орчинд байршуулсан байна.

Онцлог зүйл:

Утга зохиол судлал мэргэжлийн хөтөлбөр сонгох үйл ажиллагааны өмнө оюутнуудад хөтөлбөрөө сурталчлах, таниулах өдөрлөгийг бүрэлдэхүүн сургууль, УЗУСТ болон холбогдох алба нэгжийн зүгээс зохион байгуулдаг. Энэ үйл ажиллагаанд гадаад, дотоодын их дээд сургууль төгсөж салбартаа амжилт гаргаж яваа мэргэжилтнүүд өөрсдийн туршлагаа оюутан залуустай хуваалцаж “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ”, “Ирээдүйн чиг хандлагыг ойлгох” гэх мэт цуврал уулзалт ярилцлагыг зохион байгуулж зөвлөгөө өгөн ажилладаг туршлагатай.

Уран зохиол бичиг, сонирхогч оюутнуудын дунд “Давлагаа” богино өгүүллэгийн наадам, “Чөлөөт сэтгэлгээний дуулал” яруу найргийн наадмыг тогтмол явуулж хөтөлбөрийг нийгэмд сурталчлах, таниулах ажил хийдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө байхгүй байгааг анхаарах; Гоц авьяастны эрэлд гарах, тэдэнд зориулж тэтгэлэг олгодог болох
- Хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах ажлыг багш, тэнхим, нэгж, сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгадаг байхад анхаарах;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдлыг хангах, мэргэжлийн ач холбогдол, нийгэмд эзлэх байр суурь, давуу талыг нийтэд таниулахад чиглэсэн маркетингийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Маркетингийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө гаргаж үүнд мэдээллийн технологийн хөгжлийн ололтыг ашиглах бодлого баримтлах;
- Суралцагчдын сайн дурын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үнэлгээг нарийвчлан тогтоож дүгнэдэг байх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр сургуулийн албан ёсны цахим хуудас, мэдээллийн хэрэгслүүдээр сургууль, салбар, нэгжүүдийн үйл ажиллагааны талаар олон нийтэд тогтмол мэдээлж хэвшсэн. МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн танилцуулга, суралцахуйн зорилтод үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр дараах албан ёсны эх сурвалжуудаар түгээдэг. Үүнд:

- ✓ <https://www.num.edu.mn/> - МУИС-ийн цахим хуудас
- ✓ <https://elselt.num.edu.mn/> - МУИС-ийн Элсэлтийн цахим хуудас
- ✓ <https://burtgel.num.edu.mn/negdsen> - МУИС-ийн Бүртгэлийн нэгдсэн систем
- ✓ <https://graduate.num.edu.mn/> - Ахисан түвшний сургуулийн цахим хуудас
- ✓ <https://sas.num.edu.mn/> - Шинжлэх ухааны сургуулийн цахим хуудас
- ✓ <https://www.facebook.com/MuisLitArt/> МУИС-ийн Утга зохиол урлаг судлалын тэнхим (пэйж хуудас)

- ✓ <https://www.facebook.com/groups/102912840278114/> МУИС-ийн Утга зохиол урлаг судлалын тэнхим (групп хуудас)

Онцлог зүйл:

МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн танилцуулга, суралцахуйн зорилгод үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр дараах албан ёсны эх сурвалжуудаар түгээдэг.

Жил бүр мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулж хэвшсэн, мөн тэнхимийн түүхийн баримтат кино хийсэн (2021 оны 3 сарын 23-нд)

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй, ил тод түгээх талаар хийж буй олон талт ажлыг нэгтгэж дүгнэж системтэй болгон бичээгүйг анхаарах;
- Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллагааг бэхжүүлж, нийгэмд үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахад анхаарч ажиллах, сургуулийн бодлогод тусгах;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн ил тод байдлыг хангах, мэргэжлийн ач холбогдол, давуу талыг олон нийтэд сурталчлан таниулах ажилд багш, тэнхим, нэгж бүрийн оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган дүгнэдэг байх;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалтыг гаргах, цахим сан бүрдүүлэх;

Шаардлага:

- Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц маркетингийн өөрийн гэсэн хөтөлбөр төлөвлөгөөтэй болох;

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Монгол улсын дээд боловсролын тухай хууль, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2013 оны 03-р сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04-р сарын 06-ны өдрийн А/194 тоот “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал, Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох журам” болон бусад холбогдох эрхзүйн актыг үндэслэн элсүүлдэг. МУИС. ШУС. ХУС-ийн нийт элсэгчдийн 2.6 хувь нь тус

хөтөлбөрт элсдэг. Тус хөтөлбөрөөр элсэгчид нь “Бакалаврын өдрийн хөтөлбөрт шинээр элссэн суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалт”-д 63.6 хувь хамрагдсан.

Элсэлтийн цахим гарын авлагатай бөгөөд ЭЕШ-ийн 750-780 дээш оноотой элсэгчид сургалтын төлбөрийн 50-100 хувьтай тэнцэх тэтгэлэг олгодог. Тус хөтөлбөрт суралцагчдын сүүлийн 5 жилийн дундаж оноо 606.9 байгаа нь элсэгчдийн сурлагын чанар сул байгааг илэрхийлж байна. Мөн оюутны тоо цөөн байна. Тухайлбал, 2022.02.18-ны байдлаар нийт 67 оюутан суралцахаас 20 оюутан идэвхгүй, 4 оюутан чөлөө авсан, идэвхтэй суралцаж байгаа 43 оюутан байна. Цахим хэлбэрээр www.burtgel.num.edu.mn элсэх боломжтой. Тус хөтөлбөрт элссэнээр сонин сэтгүүлийн редактор, хариуцлагатай редактор, утга зохиол судлаач шүүмжлэгч, хэвлэлийн газрын редактор зэрэг мэргэжлээр хувирах боломжтой байгаа нь тус хөтөлбөрөөр элсэх хөшүүрэг болж байна.

Онцлог зүйл:

Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд оюутан бүрэлдэхүүн сургуульд элсээд ерөнхий суурийн 24 багц цаг судалсны дараа мэргэжлээ сонгох боломжийг бүрдүүлдэг онцлогтой болсон.

Анхаарах асуудал:

- Элсэгчийн тоо /нийт идэвхтэй суралцаж буй 43 оюутантай/ болон өндөр оноотой суралцагч элсүүлэх тал дээр анхаарах;
- Уран зохиолд сонирхолтой энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх хүүхэд элсүүлэхэд анхаарах;

Зөвлөмж:

- Шүлэг зохиол бичдэг, сонирхдог гоц авьяас бүхий суралцагчийг урилгаар элсүүлж суралцуулах;
- Тус хөтөлбөрийн онцлогийг шингээн сургалтын төлбөрийн хөшүүрэг ашиглаж элсэгч татаж нийт элсэгчийн тоог нэмэгдүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Суралцагчид үзүүлэх үйлчилгээг хариуцдаг “Оюутан төгсөгчийн хэлтэс” нь хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, оюутан солилцоо, санхүүгийн дэмжлэг, цахим үйлчилгээ, оюутны тэтгэлэг, эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ, дотуур байр орон сууцны үйлчилгээ, судалгаа болон санаачлагыг дэмжих үйлчилгээ, оюутны нийгэмд хандсан үйлчилгээ, Боловсролын зээлийн үйлчилгээ, соёл, спортын үйлчилгээ, цахим үйлчилгээ зэрэг 11 төрлийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг.

Багш ажилчдын зүгээс оюутанд зөвлөн туслах үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа нь 56.4 хувийн эерэг үзүүлэлттэй. Антоон Мостаэрт монгол судлалын төвийн “Оюутан судлаач” судалгааны хөтөлбөрт амжилттай хамрагддаг. 2017-2021 оны хооронд нэр бүхий 6 оюутан 1-3-р байр эзэлсэн. Тэнхимийн зүгээс хичээл сонголт баталгаажуулалт, эрдэм шинжилгээний ажлын зөвлөгөө, сурах бичиг гарын авлагын

талаарх зөвлөгөө, оюутны нэгдэл, клубын зөвлөгөө, тэтгэлэг гэх мэт 5 зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдгээс хичээл сонголт баталгаажуулалтын үйлчилгээг 90.9 хувь нь авсан байна. Мөн МУИС-ийн зүгээс оюутны судалгаа, эрдэм шинжилгээг сайжруулахад чиглэгдсэн “МУИС-ийн индэр”, бие бялдар, эв нэгдэлд чиглэсэн “МУИС-ийн оюутны спортын их, бага наадам”, урлаг соёлын авьяасыг нээн илрүүлэх хөгжүүлэх зорилго бүхий “NUM cover дууны тэмцээн”, “Оюутны урлагийн их бага наадам”, гэмт хэрэг аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилготой ЦЕГ-ийн хар тамхитай тэмцэх хэлтэс, тээврийн цагдаагийн албадтай хамтран “Хичээл өдөр”, эрүүл мэндэд чиглэсэн “Цусны донор” зэрэг үйл ажиллагаа, сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг байна.

Онцлог зүйл:

Суралцагчийн суралцах явцад үүсдэг хүндрэлүүдийг даван туулах, ирээдүйн ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлоход туслах сэтгэлзүйн зөвлөгөө өгдөг “Оюутан төгсөгчийн хэлтэс”-тэй.

Анхаарах асуудал:

- Төгсөх курсийн 6 хүүхдийн 5 нь хэвлэл мэдээллийн салбарт /редактор/ ажиллана гэж байгаа нь утга зохиол судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж төгсөгчийг үндсэн мэргэжлээр нь /утга зохиол судлаач/ ажилуулахад тус дөхөм үзүүлэх сургалт, зөвлөгөө, чиг баримжаа олгох шаардлагатайг харуулж байна.

Зөвлөмж:

- Мэргэжлийн чиг баримжаа олгох зорилго бүхий зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг цахим хэлбэрийг хөгжүүлэх, онлайнар зөвлөн туслах бололцоог нээж Facebook, Twitter зэргээр байнга зөвлөгөө өгөх боломжтой групп чат болон бусад хэлбэрүүдийг түлхүү ажиглаж цаг завьг хэмнэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

МУИС-ийн “Оюутан төгсөгчийн хэлтэс”-ээс суралцагчийн суралцах нөхцөл бололцоог дэмжин ажиллах 30 клуб үйл ажиллагаа явуулдаг. Түүнд тус хөтөлбөрийн оюутнууд идэвхтэй хамрагддаг. Тэнхимээс суралцагчийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх 2 клуб үйл ажиллагаа явуулдаг. Мөн долоо хоног тутмын дугуйлангийн үйл ажиллагаа нь суралцагчдын шинэ бичсэн шүлгүүдийг хэлэлцэж санал бодлоо солилцож мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд дөхөм тус үзүүлдэг.

“Утга зохиолын нэгдэл” болон “Өлзий” нэгдлээс 2018 онд 22 шүлэгчийн 80 шүлгийг “Сэрэхүйн гүнд” гэдэг нэртэйгээр хэвлүүлсэн. “Чөлөөт сэтгэлгээний дуулал” улсын их дээд сургуулийн оюутнуудын яруу найргийн наадмыг 2 жил тутамд, “Давалгаа” богино өгүүллэгийн наадмыг 2 жил тутамд, “Энсэх цаг” зохиолчдын уулзалтуудыг хийж сүүлийн 5 жилд салбартаа нэр хүнд бүхий 26 зочин урьж уран зохиолын онол, туурвилзүй шүүмж судлалын сэдвээр оюутнуудад яриа танилцуулга хийжээ. Тэнхимийн брэнд утга зохиолын нэгдэл 1961, Өлзий нэгдэл 2010 оноос үйл ажиллагаа явуулж буй уламжлал болон тогтсон нэгдэлтэй.

Онцлог зүйл:

Утга зохиолын тэнхимийн дэргэдэх “Утга зохиолын нэгдэл” дугуйлан нь энэ чиглэлийн нэрт эрдэмтэн судлаачдыг төрүүлэн гаргасан нэр хүндтэй, өөрийн гэсэн сургалтын онцлогтой, олон жилийн түүхтэй дугуйлан. “Утга зохиолын нэгдэл” дугуйлан нь зохиолч яруу найрагч бэлтгэх, уран сайхны сэтгэлгээг хөгжүүлэхэд анхаардаг бол “Өлзий” нэгдэл нь суралцагчийн эрдэм шинжилгээний хэл найруулгыг хөгжүүлэх, боловсруулахад чиглэгдэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн эрүүл мэнд, сайн дурын үйл ажиллагаа, оюутны өөрөө удирдах клуб, дугуйлангийн тоо, суралцагчийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах;

Зөвлөмж:

- Мөнгөн урамшууллын хэлбэрийг нэмэгдүүлэн оюутны оролцоог хангах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

МУИС-ийн шилжилт хөдөлгөөнийг “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам батлах тухай” 2019.11.14-ний А/483 тоот тушаалаар зохицуулагддаг. 2016-2021 оны хооронд гадаадад суралцахаар 2, сургуулиас чөлөөлөгдсөн 5, дотоодын бусад сургуульд шилжсэн 2, МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль руу шилжсэн 8, МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас шилжиж ирсэн 5 оюутан байна.

Сүүлийн 5 жилд нэг жилд 4-5 оюутан шилжин явах, шилжин ирэх, гадаад бололн дотоодын их сургуульд суралцахаар явах шилжилт хөдөлгөөн хийж, мөн сургуулиас чөлөөлсөн байна.

Гадаадаас шилжин ирж буй оюутны дүнг МУИС-ийн захирлын 2021 оны 12-р сарын 02-ны өдрийн А/361 тушаалаар дүйцүүлэн тооцдог. Одоогоор гадаадаас шилжин ирсэн илрэл байхгүй байна. Одоогоор өөр сургуулиас шилжин ирсэн тохиолдол байхгүй бөгөөд шилжин ирсэн 10 суралцагч МУИС-ийн бусад бүрэлдэхүүн сургуулиас шилжин иржээ.

Онцлог зүйл:

Дотоодын багц цагаар /кр/ хэмждэггүй сургуулиас шилжин ирвэл танхимын 72 цагийг 1 кр гэж тооцон дүйцүүлдэг.

Анхаарах асуудал:

- Дотоод, гадаадын өөр сургуулиас шилжин ирж суралцахгүй байгаа шалтгааныг судлах;

Зөвлөмж:

- Суралцагчийн мэргэжлийн дур сонирхол, авьяас чадварыг улс, олон улсад сурталчилсан наадам уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж тус хөтөлбөрийг сурталчлах;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

МУИС-ийн захирлын 2015 оны 6-р сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан сургалтын журмын 4.12.4-т заасны дагуу дээд боловсролын бакалаврын зэргийн болзол хангасан суралцагчил төгсөлтийн албарын комиссын шийдвэрийг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар диплом, дидломын хавсралт, энгэрийн тэмдэг олгодог. Диплом бичилтийг англи, монгол хэлээр /кирил ба монгол бичиг/ хосолсон хэлбэрээр бичиж хэвлэн гаргадаг. Дипломын нүүр нь МУИС-ийн тамга тэмдэгээр баталгаажин МУИС-ийн удирдах зөвлөлийн дарга болон МУИС-ийн захирлын гарын үсгээр баталгааждаг бол хавсралт нь МУИС-ийн элсэлт, бүртгэлийн хэлтсийн дарга, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын хэлтсийн даргын гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулдаг. Тус хөтөлбөрөөр 2016-2017 онд 16, 2017-2018 онд 11, 2018-2019 онд 20, 2019-2020 онд 10, 2020-2021 онд 11 оюутан, сүүлийн 5 жилд 68 оюутан төгссөн байна.

Онцлог зүйл:

Жилд 2 удаа төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд төгсөгч нь хувийн төлөвлөгөө, хичээл сонголтоос шалтгаалан хавар эсвэл намрын улирал төгсөх боломжтой.

Анхаарах асуудал:

- Тус мэргэжлийн онцлог болох утга зохиолын мэргэжлийн сургуулийн болон улс олон улсын шинж чанартай /"Давалгаа" богино өгүүллэгийн наадам, "Цагаан уул" хайрын богино шүлгийн наадам гэх мэт/ янз бүрийн томоохон уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн тохиолдолд диплом дээр сайн дурын ажлын үнэлгээнд тооцож тэмдэглэх;

Зөвлөмж:

- Суралцах явцад мэргэжлийн ур чадвараараа онцгойрсон оюутны ур чадвар, авьяас чадварыг үнэлсэн хавсралтыг олгох;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

УЗС хөтөлбөр нь 2021-2022 оны хичээлийн жилд таван үндсэн багш, нэг гэрээт багш, нэг цагийн багш, нэг туслах ажилтантай хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Албан тушаалын зэрэглэлээр: 1 профессор, 4 дэд профессор, 1 гэрээт дэд профессор ажиллаж байна. Үндсэн орон тооны багш нарын 85.8 хувь нь докторын зэрэгтэй, 14,2 хувь нь магистрын зэрэгтэй байна Нэг багш Кембрижийн их сургуулийн Корпус Кристи коллежид докторантурт суралцаж байна.

МУИС-д профессор, багш ажиллуулах журамд заасны дагуу багш нар 3 жил тутамд профессор, дэд профессорын шаардагыг хэрхэн хангасан байдлыг тайлагнан, хангасан багш нар 3 жил тутам журмын дагуу зэрэглэл дэвшүүлэн ажиллуулдаг. УЗС-ын хөтөлбөрийн багш нараас сүүлийн таван жилийн тухайд гурван дэд профессорын зэрэглэлд дэвшиж ажилласан бол хоёр багш шалгуур үзүүлэлтийн болзол хангаагүй тул профессороос дэд профессорын зэрэглэлд буурч ажиллаж байна.

Онцлог зүйл:

Тус хөтөлбөрийн багш нараас нэг сэдэвт бүтээл 2, шилдэг өгүүлэл 2 багш тус тус шалгарсан сайн үзүүлэлт байна. УЗС-ын хөтөлбөрийн багш нараас сүүлийн таван жилийн тухайд 2018 оноос С.Дашдэжид, 2021 оноос Г.Нарантунгалаг, Д.Нямдорж нар дэд профессорын зэрэглэлд дэвшиж ажилласан бол Б.Хишигсүх, Г.Галбаяр нар шалгуур үзүүлэлтийн болзол хангаагүй тул профессороос дэд профессорын зэрэглэлд буурч ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- 2021-2022 оны хичээлийн жилд хөтөлбөрийн нэг багшид 6.7 оюутан ноогдож байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд нэг багшид оногдох суралцагчийн харьцаа өсөх хандлагатай байгаа боловч 2019 онд ЕБС-ийн төгсөгчид цөөн байснаас шалтгаалан их дээд сургуулийн элсэгчдийн тоо буурсан. Хэрэв хөтөлбөрийн багш нарын тоог ерөнхий суурь хичээл болон хамтарсан хөтөлбөрийн оюутны тоонд харьцуулбал нэг багшид оногдох суралцагчийн тоо илүү өндөр гарах болно. Сургууль болон тэнхимийн зүгээс хөтөлбөрийн мэргэжлийн багш нарын тоог нэмж, багш суралцагчийн зохистой харьцааг барих бодлого барих;
- Сургалтын үйл ажиллагааны 48 цагийг 1 ББц гэж тооцдог ба үүнээс суралцагчдад зөвөлгөө өгөх 6, суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх 14 цагийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэх үйл явцыг тодорхой болгож өгөх;

Зөвлөмж:

- Багш, суралцагчдын тооны харьцаанд шинжилгээг тогтмол хийж ажлаа төлөвлөдөг байх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

Guest lecture program Багш өөрийн лекцийн хичээл дээр тухайн шинжлэх ухааны онол, практикийн мэдлэг, туршлагатай, эрдэмтэн, судлаач, иргэний нийгмийн зүтгэлтнийг урьж лекц уншуулах, ярилцлага зохион байгуулах хэлбэрээр уг хичээлийн агуулга, арга зүйг баяжуулан, суралцахуйн үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

“Залуу эрдэмтдийн индэр - NUM speaker series” хөтөлбөрт 2019 оны 11 сарын 29-нд зочноор хөтөлбөрийн багш доктор Д.Нямдорж “Монгол төрийн бэлгэдлийн уламжлал, шинэчлэл” сэдвээр өөрийн судалгааны ажлын явц, үр дүнг танилцуулжээ.

Сургууль, тэнхимийн зүгээс багш нарын хөгжил, сургалт, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх, баяжуулахад тогтмол анхаарч ирсэн. Тухайлбал, 2021 оны 01 сарын 20-ны А/13 тоот журмаар “Багш ажилтны хөгжлийг дэмжих зардлын санхүүжүүлэх журам”-ыг шинээр баталсан байна (МУИС 2021). Энэ журам нь 2021 онд батлагдсан хэдий ч тус санхүүжилтийг 2016 оноос хойш жил бүр олгож байна. УЗС-ын хөтөлбөрийн хувьд 2-3 сая төгрөг, үүнийг нэг багшид оноохоор хувааж үзвэл нэг багш дунджаар 300-400 мянган төгрөгийн ногдох дэмжлэгийг жил бүр авч өөрийн мэргэжлийн хөгжил, сургалт, арга зүй, эрдэм шинжилгээ судалгааны чадавхаа дээшлүүлэхэд зарцуулж байна.

Онцлог зүйл:

Сүүлийн зургаан жилийн хугацаанд хөтөлбөрийн багш нар боловсрол судлалын болон мэргэжил дээшлүүлэх сургалтад 62.5% хамрагдсан. Судалгааны суурь зардлын санхүүжилтэд хамрагдан 31 сая төгрөгийн зардал (Хавсралт 6.2.1) авч олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцсон, ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлсэн, хээрийн шинжилгээнд явсан, судалгааны ном, эх хэрэглэгдэхүүн худалдан авахад тус тус зарцуулжээ.

Анхаарах асуудал:

- Багш нарыг гадаадын нэр хүндтэй их сургуулиудад урт хугацаагаар ажиллуулах, мэргэжил дээшлүүлэх;
- Багш бүр ажлын байран дээрээ өөрийн санаачилгаар гадаад, дотоодын онлайн сургалт семинарт хамрагдаж хөгжих, БМДИ-ийн Багшийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтуудад хамрагдах;
- Багшийн хөгжлийн судалгааг тогтмол хийх, энэ талаарх мэдээллийн санг чанартай бүрдүүлэх;

Зөвлөмж:

- Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Утга зохиол судлал хөтөлбөрийн багш нар нь сүүлийн 5 жилийн хугацаанд МУИС-ийн санхүүжилттэй судалгааны төсөл 3, хөтөлбөрийн үр дүнг сайжруулахад чиглэсэн ерөнхий суурийн болон мэргэжлийн хичээлийн сурах бичиг зохиох захиалгат 3 төсөл хийж гүйцэтгэсэн.

Онцлог зүйл:

Утга зохиол судлалын хөтөлбөрийн багш нар 2016-2020 онуудад олон улсын хамтарсан төсөл, үндэсний байгууллагуудтай хамтарсан 1 төсөл, дотоодын санхүүжилттэй 3 төсөл, захиалгат төсөл, гэрээт ажил 3, олон улсын эрдэм шинжилгээний хурал 3, дотоодод эрдэм шинжилгээний хурал 1 тус тус зохион байгуулсан. Мөн сүүлийн таван жилд гадаадад 5 өгүүлэл, дотоодод 40 өгүүлэл хэвлүүлж, 29 илтгэл гадаадад, 26 өгүүлэл дотоодод тус тус хэлэлцүүлсэн. Тэнхимийн багш нарын нийт 4 сурах бичиг, 11 гарын авлага хэвлүүлсэн байна.

Web of Science, Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд сүүлийн 5 жилийн хугацаанд Г.Нандинбилиг, Ш.Туяа нар 3 өгүүлэл хэвлүүлсэн.

Анхаарах асуудал:

- Утга зохиол судлалын хөтөлбөрийн багш нарын өндөр түвшний төсөл удирдах, WOS, SCOPUS-д бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоог нэмэгдүүлэхийн тулд багш нарынхаа академик англи хэлний түвшинг дээшлүүлэх тал дээр гадаад дотоодын байгууллагуудаас туршлага судлан, санаачилгатай ажиллах;
- Багш нарын бүтээлээс ишлэл авсан байдлын судалгааг гаргах;

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөг багш бүр боловсруулж хэрэгжүүлэх;
- Суурь судалгааг цаашид өргөжүүлэх, төсөв санхүүжилтыг олон эх үүсвэрээс эрж хайх;
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо, төрөл, чанарт анхаарах;
- Утга зохиол судлалаар хөтөлбөр хэрэгжүүлдэг бусад их дээд сургуулиудтай хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн багш нарын сүүлийн 5 жилийн А цагийн гүйцэтгэл дундажаар 95.14 багц цаг, илүү цагийг харьцуулан харвал дундажаар 137.112 багц цагийн гүйцэтгэсэн байна. 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд бусад жилүүдийнхээс илүү цаг өндөр гарч байгаа нь зөвлөх профессоруудын гэрээний хугацаа дууссан, цагийн багшаар заалгахаас багш нар өөрсдөө хичээлээ орохыг чухалчилсан зэргээс болсон байна.

Б цагийн гүйцэтгэл дундажаар 2017-2018 хичээлийн жилд 72.3 багц цаг, 2018-2019 оны хичээлийн жилд 91.4 багц цаг байгаа нь багш нарын судалгааны ажилдаа анхаарч эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичих идэвх нэмэгдсэн болохыг харуулж байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан сүүлийн хоёр жилийн Б.В цагийн гүйцэтгэлийг 50 хувиар бууруулан тооцсон боловч 2019-2020 онд 43.68 багц цаг, 2020-2021 онд 70.81 багц цагийн гүйцэтгэлтэй байна.

Онцлог зүйл:

Багшийн сургалтын ажилд үнэлэлт өгөх сэтгэл ханамжийн судалгааг жил, улирлал бүр авдаг. Судалгаагаар оролцсон оюутнуудын 80 хувь нь сайн, маш сайн гэсэн хариулт өгсөн байна. Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр хэлэлцүүлэг хийдэг.

Анхаарах асуудал:

- Анги удирдсан багш/ зөвлөх багш бүр ангийн ажлын хавтасастай байх. Түүнд, Ангийн дэлгэрэнгүй судалгаа (жил бүрээр), Ангийн ажлын төлөвлөгөө (жил бүрээр), Төлөвлөгөөний дагуу явуулсан болон явуулах ажлын удирдамж (жил бүрээр), Ангийн хурлын протокол (жил бүрээр), Ангийн дүн улирал, жилээр гарган (ахиц, бууралтыг графикаар харуулсан байх, жил бүрээр), Ангийн журнал хөтлөлтөнд хяналт тавих,
- Өөрийн үнэлгээний тайлан бичих загвар, үнэлэх журам, шалгуурыг мөрдөх
- Багшийн үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын талаар дэлгэрүүлэх

Зөвлөмж:

- Суралцагчдын суралцах хугацаандаа 4 удаа хийдэг ангийн ажил болон болзол хангасан оюутнуудын бичдэг төгсөлтийн ажлын сэдвийн судалгаа, дүнгийн анализыг сүүлийн 5 жилээр гаргах;
- Багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний нийцэл, түүнд анализ хийх;
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлж дүгнэх удирдамж, заавар, зөвлөмж боловсруулж хүргэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

Утга зохиол, урлаг судлалын тэнхим нь утга зохиол, урлагийн чиглэлээр сургалтын хөтөлбөрийг сайжруулах, хамтран ажиллах талуудын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс тус салбарын мэргэжлийн багш нарын төлөөлөл болох таван хүний бүрэлдэхүүнтэйгээр Хөтөлбөрийн дэд хороо ажиллаж ирсэн (ШУС-ийн захирлын 2017.12.05-ны Б/205, 2021.02.20-ны Б/16 тоот тус тус тушаалын хавсралт), ажиллаж байгаа бөгөөд дурдсан хугацаанд дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнд;

- ✓ Бакалаврын үндсэн мэргэжлийн хөтөлбөрт зарим өөрчлөлт оруулах (Туурвил зүй, Уран зохиолын ерөнхий онол, Уран зохиолын найруулга зүй, Уран зохиолын дидактик, Монголын орчин үеийн уран зохиол гэх мэт)
- ✓ Ерөнхий суурь хичээлийн анги бүрдэлт, ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн сурах бичгийн тухай

- ✓ МУИС-ийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн сурах бичиг зохиох төсөлд санал оруулах, хэрэгжилт, үр дүн
- ✓ Сургалтын хөтөлбөрийн журамд санал хүргүүлэх
- ✓ Ерөнхий суурийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх (Илтгэх урлаг, Монгол соёл иргэншил, Урлагийн боловсрол гэх мэт)
- ✓ Нэгж хичээлийн хөтөлбөрийг хянан засварлах, сайжруулан шинэчлэх
- ✓ Батлагдсан хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөнд мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн залгамж, холбоог хэлэлцэж өөрчлүүлэх, ХЧБХ-нд хүсэлт гаргаж хүргүүлэх (Соёл судлал, Туурвил зүй ...)

Онцлог зүйл:

Утга зохиол, урлаг судлалын тэнхим нь утга зохиол, урлагийн чиглэлээр сургалтын хөтөлбөрийг сайжруулах, хамтран ажиллах талуудын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс тус салбарын мэргэжлийн багш нарын төлөөлөл болох таван хүний бүрэлдэхүүнтэйгээр Хөтөлбөрийн дэд хороо ажиллаж ирсэн (ШУС-ийн захирлын 2017.12.05-ны Б/205, 2021.02.20-ны Б/16 тоот тус тус тушаалын хавсралт), ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн үр дүнгийн ач холбогдол ба гүйцэтгэлийг шууд болон шууд бус аргуудаар үнэлсэн үнэлгээний нэгдсэн сангай болох;
- Чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах ажлын төлөвлөлт гаргах;
- Чанарын баталгаажуулалт, хяналт үнэлгээний ажлын явц, үр дүнд тухай бүрт нь шинжилгээ хийх;

Зөвлөмж:

- Хэрэгжүүлж буй хөтөлбөрөө ижил түвшний бусад сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулан судалж, давуу болон сул талаа олж харах;
- Хөтөлбөрт хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

Шаардлага:

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах;
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмшсэн ур чадварын матриц гаргах;

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

2016-2017 оны хичээлийн жилээс 2020-2021 оны хичээлийн жилийн хугацаанд Утга зохиол судлал хөтөлбөрөөр нийт таван төгсөлт хийсэн бөгөөд тухайн хугацаанд нийт 68 оюутан тус хөтөлбөрт хамрагдан суралцаж, судалж төгссөн байна.

Утга зохиол судлал хөтөлбөрийн төгсөгчдийн дийлэнх олонх буюу 84.4 хувь (43 төгсөгч) сургуулиа төгссөний дараа ажилд орсон гэж хариулсан байна. Харин судалгаанд оролцогчдын 5.9 хувь буюу 3 төгсөгч нэгээс дээш жил ажил хайсан гэж хариулсан бол 9.8 хувь нь (5 төгсөгч) хариулахгүй боломжгүй гэжээ.

Төгсөгчдөөс ажилд ороход тулгарсан хүндрэлийг тодруулахад, 39.6 хувь (19 төгсөгч) хүндрэл байгаагүй, 27.1 хувь (13 төгсөгч) цалин, хангамж муу, 14.9 хувь (7 төгсөгч) ажлын байранд гүйцэтгэх ажил тодорхойгүй, 12.6 хувь (6 төгсөгч) ажлын байр хомс хэмээн хариулсан байна

Онцлог зүйл:

Хөтөлбөрт элсэгчдийн сүүлийн таван жилийн дундаж ЭЕШ-ын оноо 606.9, төгсөгчдийн голч дүнгийн дундаж 2.98 байгаа нь сургалтын үйл ажиллагаа жигд түвшинд байна.

Судалгаанд хамрагдсан нийт төгсөгчдийн 38.9 хувь нь мэргэжлийн ажил эрхэлж байгаа хэдий ч хөтөлбөрийн хөрвөх чадвар, боломжоо ашиглан өөр өөр салбарт ажиллах боломжтойг харуулж байна. Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг, хамт олон төгсөгчидтэйгөө байнгын эргэх холбоотой ажиллаж, хөтөлбөрийн болон мэргэжлийн хэрэгцээ шаардлагын судалгааг таван жил тутам тогтмол хийх нь амжилттай хэрэгжиж байгаа хөтөлбөрийнхөө чанар, хөгжлийг улам сайжруулах боломж бололцоо олгох юм.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүнг тодорхой гаргах
- Хөтөлбөрийн салбар хорооны бүрэлдэхүүнд оюутны төлөөллийг оруулах
- Төгсөгчдийн хөгжлийг дэмжих, тэднээс мэргэжлээрээ хөгжих хэрэгцээний судалгааг тогтмол хийж, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх
- Докторын зэрэг хамгаалсан төгсөгчдийн тоо, чанар

Зөвлөмж:

- Удирдлага, мэдээллийн системийг хөтөлбөрийн хяналт үнэлгээнд түлхүү ашиглах;
- Төгсөгчдийн ажил эрхлэлт, карьерын өсөлтийн судалгааг 5 жилээр гаргаж дүгнэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/. Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл:

“Утга зохиол судлал” хөтөлбөрт суралцаж төгссөн төгсөгчдөөс нэр бүхий 20 суралцагчид мэргэжлээрээ дараагийн түвшинд дотоод, гадаадын их сургуулиудад гүнзгийрэн суралцаж байна. Энэ нь “Утга зохиол судлал” хөтөлбөр мэргэжлийн судлаач, эрдэмтдийг бэлтгэдэг болохыг харуулж байна.

“Утга зохиол судлал” хөтөлбөрт суралцаж төгссөн төгсөгчдийн олонх нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад ажилладаг ба тэдний зарим нь мэргэжлийн чиглэлийн үндэсний хэмжээний уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцсоор байна. Тухайлбал,

-2013 оны төгсөгч Т.Тэгшжаргал 2016 онд “Ц.Балдорж сангийн шилдэг шагнал”,

-2015 оны төгсөгч Б.Алтанхуяг 2018 онд “Алтан өд” шагнал,

-2019 оны төгсөгч Э.Дэвээжаргал 2020 оны “Алтан өд”-ийн тусгай байрын шагнал,

-2022 онд 4 ангид суралцаж буй оюутан М.Мөнхжаргал “Сэтгүүлч Батдорж сан”-гийн шагнал тус тус хүртсэн байна. Энэ бүхэн нь манай хөтөлбөрт суралцаж төгссөн төгсөгчид хэвлэл мэдээллийн байгууллага, уран зохиолын салбарт амжилттай ажиллаж байгааг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Өмнөх сургалтын хөтөлбөр болон одоогийн сургалтын хөтөлбөрийн үеийн багш, оюутны саналыг харьцуулах;
- Төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн эсэхийг баталгаажуулах, нотлох баримт бичгийн судалгаатай болох;

Зөвлөмж:

- Дотоод, гадаадын сургуулиудад ахисан түвшний хөтөлбөрт суралцсан төгсөгчдийн судалгаатай болох;
- Хөтөлбөрийн нэр хүнд үнэлэмжийн судалгааг авч, он оноор ахиц өөрчлөлтийг илрүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			2.2. Хэсэгчлэн хангасан. Суралцагчид үндсэн утга зохиол судлал мэргэжлээр дадлагын
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			4.5 Хэсэгчлэн хангасан. Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц маркетингийн өөрийн гэсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6	Багшийн үйл ажиллагаа	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	+			7.1 Хэсэгчлэн хангасан. Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо үгүй. Хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмшсэн ур чадварын матриц байхгүй.
ДҮГНЭЛТ		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Утга зохиол судлал гэсэн хөтөлбөрийн гол цөм агуулга болох судлаач бэлтгэх тал дээр түлхүү анхаарсан төлөвлөлт хийх; - Багш нарын оролцоог дээшлүүлж сонголт болон чөлөөт сонголтыг судлаач чиглэлээр хийхэд туслах; - Сэтгүүлчийн сертификац олгох хичээл нэмэх;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Дадлагын хичээлийг зайлшгүй хоёроос доошгүй хийх; - Утга зохиол судлаачийн дадлагыг зайлшгүй хийхийг хөтөлбөрт тусгах;
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Анги танхимын агааржуулалт болон хоолны газартай болох асуудлыг сургуулийн удирдлагуудад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх; - Их завсарлагаатай болгож суралцагчдын идэвх оролцоо амралт чөлөөт цагаа зөв төлөвлөх боломжийг хангаж өгөхөд анхаарах;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, хяналт тавих, ил тод байдалд тогтмол дүн шинжилгээ хийх; - Хөтөлбөрийг сурталчлах, олон нийтэд ил тод түгээх үйл явц тогтсон, хуучинсаг байдалтай байгааг онцгой анхаарч, хөтөлбөрийг сурталчлахтай холбоотой санхүүжилтийн эх үүсвэрийг төсөв төлөвлөгөөндөө тодорхой тусгах; - Дотоодын болон гадаадын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг их дээд сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Элсэгчийн тоо цөөн, өндөр онооны тэтгэлэгт хамрагдаж чадахгүй байгааг анхааран элсэлтийн сурталчилгааг сайтар хийх; - Элсэгчийн авьяас чадварт тулгуурласан уян хатан нөхцөлүүдийг санал болгох; - Гадаад дотоодоос болон бүрэлдэхүүнээс бусад сургуулиас суралцагч шилжиж ирэхгүй байгаад анхаарч шилжилт хөдөлгөөний дүрэм журам, кредит тооцох нөхцөлөө уян хатан болгоход анхаарах;
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын бодит ачааллын судалгааг хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс тогтмол хийж, хүний нөөцийн тогтвортой, хүлээн зөвшөөрөгдсөн байдалд анхаарах, - Багшийн багшлахуйн хөгжлийг дэмжсэн ажлуудыг түлхүү төлөвлөх, багшийн хөгжлийн судалгааг тогтмол хийж, мэдээллийн санг чанартай бүрдүүлэх; - Багшийн нийгэмд чиглэсэн үйлчилгээ, сургалтын үйл ажиллагаа хөтөлбөрийн үр дүнг улам сайжруулахад чиглэж байх;
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө боловсруулах; Ялангуяа хөтөлбөрийг ижил түвшний бусад сургуулиудын сургалтын хөтөлбөртэй харьцуулан судалж, давуу болон сул талаа олж харах,

	<p>тусгах, хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийг сонирхогч болон оролцогч талуудын оролцоог хангахын зэрэгцээ уг хөтөлбөрөөр суралцаж төгсөгчдийн эзэмшсэн ур чадварын матриц гарган, давуу болон сул талыг тодорхойлж, цаашид хөтөлбөрийн сайжруулалт, хөгжүүлэлт хийх; - Цаашид төгсөгчдөөсөө магистрын хөтөлбөрт элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, шилдэг төгсөгчдийн туршлага, арга зүйг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зэрэг дээр дорвитой ажлыг санаачлан хэрэгжүүлэх; - Мэргэжлийн холбоод, байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил төлөвлөж хэрэгжүүлэх, үр дүнг тооцохоос гадна хөтөлбөрийн танилцуулга, сурталчилгааг олон төрөл, хэлбэрээр хийж түгээх;
--	--

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн “Утга зохиол судлал” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Бүрэн хангасан.” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:

С.Байгалсайхан

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

П.Нармандах

Д.Өрнөхдэлгэр

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

№	Нэр	Эрдмийн зэрэг, цол	Албан тушаалын зэрэглэл	Судалгааны чиглэл
1.	Г.Нандинбилиг	Доктор, дэд проф	Профессор	Монгол аман зохиол, Монгол соёл иргэншил
2.	Б.Хишигсүх	Доктор, дэд проф	Дэд профессор	Эртний уран зохиол
3.	Г.Галбаяр	Доктор, дэд проф	Дэд профессор	Уран зохиолын онол Орчин үеийн уран зохиол
4.	С.Дашдэжид	Доктор	Дэд профессор	Монгол соёл иргэншил Эртний уран зохиол
5.	Г.Нарантунгалаг	Доктор	Дэд профессор	Орчин үеийн уран зохиол Уран зохиолын судлал, шүүмжлэл
6.	Д.Нямдорж	Доктор	Гэрээт дэд профессор	Орчин үеийн уран зохиол Монгол аман зохиол Монгол соёл иргэншил
7.	И.Жавхлан	Доктор	Гэрээт багш	Уран зохиолын боловсрол Зохиолч уран дүр бүтээх арга
8.	У.Бямбаям	МА	Цагийн багш	Уран зохиолын ерөнхий онол

II. Оюутнуудтай хийх уулзалт

№	Овог, нэр	Хэддүгээр курс
1	Э.Доржсүрэн М.Ялгуун П.Сийлэгмаа О.Номин-Эрдэнэ Л.Хүрэл-Эрдэнэ Б.Хулан Б.Бат-Эрдэнэ	2-р курс
2	М.Анухатан Т.Зулаа М.Оюунбадам З.Мөнххишиг У.Эгшиглэн	3-р курс
3	Ө.Сумъяа С.Энхцэцэг Э.Бадамханд Б.Уранчимэг Т.Мөнхжаргал Д.Туяацэцэг	4-р курс

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Ажил олгогчдыг төлөөлөл	Утас	Одоо ажиллаж буй төгсөгч
1	ШУАХЗХ-Утга зохиолын секторын эрхлэгч Г.Билгүүдэй	99005402	Б.Мөнх-эрдэнэ 2015 /ЭША/94140498

2	ШУАХЗХ-Хэлшинжлэлийн секторын эрхлэгч Э.Пүрэвжав	98221119	М.Очирцэнд 95012227
3	МУБИС МХ тэнхимийн эрхлэгч Соронзон	99070300	Янжинлхам /багш, судлаач/
4	Сити дээд сургууль-Байгалмаа	88114344	Х.Чойдогжамц 2014 99757553
5	Зам тээврийн хөгжлийн яамны хэвлэлийн төлөөлөгч Х.Болортуяа	99039343	Г.Энхгэрэл 2020 /Хэвлэлийн ажилтан /
6	Батлан хамгаалах яамны Соёмбо редакцын дарга , хурандаа Төмөрхуяг	88105659	Д.Мэндбаяр 2007 /зохиолч редактор/
7	Хэлний бодлогын үндэсний зөвлөл Ажлын албаны дарга Н.Нарангэрэл	91919031	Х.Анужин 2019 Б.Оюунханд 2019
8	Болор судар ХГ Г.Цэрэнбат	99939535	
9	Хүннү прессийн захирал Д.Ринченбумба 2010	99054987	Э.Ариунжаргал 2011
10	Өнөөдөр сонины редакци Бат-ундрах	88023206	
11	МҮОНТВ	88031338	Э. Уянга 2013 сэт/редактор
12	Eagle TV	88039717	Оюун-эрдэнэ
13	UB live сайтын эрхлэгч Ж.Тэгшжаргал 2012	88003329	
14	Эгүүр.мн сайтын эрхлэгч Ж.Мядагбадам 2009	88092724	Х.Умаахан2020
15	Дардас сайтын эрхлэгч Б.Өнөртогтох 2010	88006842	
16	Факт чек сайтын эрхлэгч С.Будрагчаа 2010	90005522	
17	“Зиндаа” сэтгүүлийн эрхлэгч	99090339	М.Дэвээжаргал 2021
18	Нийслэлийн 49-р сургуулийн сургалтын менежер	88016093	Д. Мөнхсайхан 2021
19	24 цаг.мн сайтын эрхлэгч Ононтуул	99107790 99597810	Т.Мөнхжаргал, Батчулуун /хавар төгсөнө
20	Zangi.mn эрхлэгч Э.Нарандулам	89106929	
21	“Сүүн сувд” хэвлэлийн газар Өлзийсайхан	94030194	Ө.Сумьяа 2022
22	“Эрдэм үйлс” сургалтын төв Оюунцэцэг	89671288	С.Энхцэцэг 2022

IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт

	Төгсөгчдийн төлөөлөл	Утас	Төгссөн он	Ажиллаж буй байгууллага
1	М.Дэвээжаргал	80272018	2021	“Зиндаа” сэтгүүлд сурвалжлагч
2	Э.Хонгорзул	98113203	2021	МУИС магистрантурт суралцаж буй

3	Г.Энхгэрэл	88057167	2020	Зам тээврийн хөгжлийн яамны хэвлэлийн ажилтан
4	Х.Умаахан	86230604	2020	Эгүүр.мн сайт
5	Б.Одгэрэл	88980210	2020	Өрөг.мн сайт
6	Б.Оюунханд	86186498	2019	Great act LLC
7	М.Янжиндулам	99151913	2019	Human Z сайт
8	Э.Энхсаруул	95596075	2019	Горькийн нэрэмжит УЗДС-д суралцаж буй
9	Балжинням /БНХАУ/		2019	МУИС магистрантурт суралцаж буй
10	Э. Оюун-эрдэнэ	91159114	2019	Монгол HD ТВ
11	Э.Нарандулам		2017	?
12	Б.Алтанхуяг		2016	Монцамэ тоймч
13	А.Цэнд-аюуш	94941024	2016	Ирландад суралцаж буй
14	Г. Бадамлянхуа		2015	ТВ 5
15	Б.Мөнх-эрдэнэ	94140498	2015	ШУАХЗХ-Утга зохиолын секторын ЭША
16	Х.Чойдогжамц	99757553	2014	Сити дээд сургууль
17	Э.Уянга	88031338	2013	МУОНТВ
18	Ж.Тэгшжаргал	88003329	2012	UB live сайтын эрхлэгч
19	Э.Ариунжаргал		2011	Хүннү пресс
20	М.Энхбаатар	89111391	2011	Унгарт суралцаж буй
21	Б.Риза		2011	Казахын соёлын судалгааны сайтын эрхлэгч
22	С.Будрагчаа		2010	Факт чек сайтын эрхлэгч
23	Э.Эрдэнэцэцэг	94090090	2009	Чөлөөт уран бүтээлч
24	Д.Мэндбаяр		2007	Батлан хамгаалах яамны Соёмбо редакцын редактор

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: sas@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2022.05.17 № 76/386

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн “Утга зохиол судлал” бакалаврын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн үнэлгээний тайлантай танилцлаа.

Сургууль болон хөтөлбөрийн зүгээс шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрч, цаашид хөтөлбөрийн үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ
САЛБАР ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ



Н.АЛТАНТӨГС

142203540